



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/468

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 4/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 71 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ковид-19 цар тахлын үед ковидын эмнэлгийн ажиллагаанд шилжүүлсэн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхдийн эмнэлэг рүү хүчилтөрөгч хийгээр хангах системийг өргөтгөж угсарч суурилуулах ажлын санхүүжилтэд 9 000 000 төгрөг /есөн сая/-ийг баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах нийт 9 000 000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2021 оны батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ